



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар В/192

Улаанбаатар хот

Өнөр бүл хүүхдийн төвийн эргэлтийн
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 05 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,447,000.00 /дөрвөн сая дөрвөн зуун дөчин долоон мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Өнөр бүл хүүхдийн төв /М.Өлзийчимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс, 8 нэр төрлийн 4,447,000.00 /дөрвөн сая дөрвөн зуун дөчин долоон мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устган, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Өнөр бүл хүүхдийн төв /М.Өлзийчимэг/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115070000481

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 06 ны өдрийн 0/102 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Өнөр бүл хүүхдийн төв

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХЖ-ын шийдвэр
Программ хангамж											
1	Албан хэрэг хөтлөлтийн программ	6	ш	1	200,000.00	200,000.00	200,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах
2	Архивын программ	6	ш	1	300,000.00	300,000.00	300,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах
3	Программ	7	ш	1	220,000.00	220,000.00	220,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах
4	Сүлжээ	13	ш	1	232,000.00	232,000.00	232,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах
5	Санхүүгийн программ	14	ш	1	800,000.00	800,000.00	800,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах
6	Санхүүгийн программ	8	ш	1	1,540,000.00	1,540,000.00	1,540,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах
7	Санхүүгийн программ	8	ш	1	385,000.00	385,000.00	385,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах

8	Санхүүгийн программ	9	ш	1	770,000.00	770,000.00	770,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч, шаардлага хагахгүй болсон	актлах	устгах
Программ хангамжийн дүн						4,447,000.00	4,447,000.00	-			
Нийт дүн						4,447,000.00	4,447,000.00	-			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн											
Устгах хөрөнгийн дүн						4,447,000.00					